



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/107

Есөнбулаг

Барилгын гадна фасадыг металл
хавтан болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний барилгын гадна фасадыг олон улсын стандартын шаардлага хангасан металл хавтан байхаар төлөвлөж, архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгаварт тусгах, зураг төслийг хянан батлахыг аймгийн ерөнхий архитектор (Б.Бямбадорж)-д даалгасугай.

2. Ашиглагдаж буй орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, цэцэрлэг, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний барилгын гадна фасадыг засварлаж, шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Дээр дурьдагдсан барилгын гадна фасадын ажилд БНБД, олон улсын стандартын шаардлага хангасан чанартай, иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй металл хавтан ашиглахыг барилгын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд, иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ



20/11/2023

$\frac{20}{\text{بقره}}$
 $\frac{30}{\text{مراغه}}$
 $\frac{5000}{\text{بقره}}$

[illegible]

6 .. سلیس من رعداً، قو اضم من قیام اضم اضم من اضم . اضم اضم اضم . اضم من اضم .

[illegible][illegible][illegible]

www.ck12.org